

КОМИНТЕРН БА МАХН-ЫН ЗҮГЭЭС БАНЧИН БОГДЫН ЭСРЭГ ХЭРЭГЖҮҮЛСЭН СУРТАЛ УХУУЛГЫН ТУХАЙ (1929-1937)

О.Бумдарь, доктор (Ph.D)

Дэд профессор Г.Эрдэнэбаяр, доктор (Ph.D)
МУИС, Философи, шашин судлалын тэнхим

Түлхүүр үгс: *Есдүгээр Банчин богд, БНМАУ, Япон улс*

Коминтерн болон МАХН-аас 1923 онд Төвөдөөс дүрвэж Хятад, Өвөр Монголд ирж амьдрах болсон есдүгээр Банчин Богд Лувсантүвдэнчойжиням (1883-1937)-ийг БНМАУ-ын дайсанд үзэж, зарласан юм. Энэ үеэс хойш 1930-аад оны туршид Коминтерн, түүнийг дагаад МАХН-аас Банчин богд нь Монголыг булаан эзлэх Япон, Хятадын бодлогыг хэрэгжүүлэгч, Монгол улсын тусгаар тогтнол, хувьсгалт төр засагт ихээхэн аюултай, харгис этгээд болох тухай суртал ухуулгыг Монгол, Өвөр Монголчуудын дунд идэвхтэй явуулсан байдаг. Гэвч өнөөг хүртэл энэ тухай тусгайлан судалсан нь үгүй юм. Тиймээс бид тус өгүүлэлд тухайн үед Коминтерн болон Монголын удирдагчдын зүгээс Банчин богдыг дайсанд үзсэн яриа, улмаар суртал ухуулгын ажлыг хаана, ямар зорилго, арга хэлбэрээр хэрхэн явуулж байсныг тодруулахыг зорив. Үүний тулд холбогдох архивын баримт, баримтын эмхэтгэл болон тухайн үед Монгол, Өвөр Монголд хэвлэн тарааж байсан зурагт хуудас, товхимол, сонин сэтгүүл зэрэг зарим суртал ухуулгын материалуудыг ашиглав.

Зөвлөлт, Коминтерн болон Монголын удирдагчид Банчин богдыг дайсанд үзэхэд нөлөөлсөн улс төрийн гадаад, дотоод гол шалтгаануудын талаар өмнө бичсэн нэгэн өгүүлэлдээ авч үзсэн (О.Бумдарь, 2021, хууд. 145-153) тул тэр тухай энд давтан нуршилгүй, харин 1929 оноос эхлэн Банчин богдын асуудал Коминтерн болон Монголын эрх баригчдын дунд хэрхэн

өрнөсөн үйл явдлаас эхлэн өгүүлье.

Нэг. Коминтерн болон Монголын удирдагчдаас Банчин богдыг дайсанд үзсэн нь

1920-иод оны сүүлчээр Фен Юйсян, Ян Шишиян, Ли Цунлин нар хамтарч Чан Кайшитай хийж эхэлсэн Хятадын дотоодод үүссэн дайны үеийн цэрэг, зэвсгийн хүчний тухай Улаанбаатарт ирж байсан хязгаарын мэдээнд Хятадын зүгээс Монголд цэргийн аюул учруулж болзошгүй тухай анхааруулж байв. Тухайлбал, “Хятадын генерал Янь Шишияны бие 5000 цэрэг бэлтгүүлэхээр Баруун Сөнөд ванд тушаасанд мөнхүү Вангаас Гадаад Монголын цэргүүд нэлээд боловсорсон болох тул эрхбиш арван мянган цэрэг бэлтгэх хэрэгтэй хэмээсэн ба энэхүү цэргүүдийг Замын Үүдээр дайруулан Улаанбаатар хотыг эзлэн авахаар хэлэлцэн буй хэмээжүхүй” (Архив, хууд. 8), мөн “...Баруун Үзэмчиний Овоогийн сүм хэмээх газар 800 шахам цэрэг буй ба Зүүн Үзэмчиний Хөх сүм хэмээх газар 350 шахам цэрэг буй” (Архив, хууд. 8) хэмээжээ. Тэрчлэн 1929 оны эхээр Замын-Үүдийн ангиас ирсэн мэдээнд “Жанжаахүүгээс инагш гурван тохой хэмээх газар морьтой явган 2000 шахам Ян Шишияны цэрэг буй бөгөөд энэхүү цэргүүд үхэр буу олонтой ба инагш ирэхээр завдан буй хэмээжүхүй” (Архив, хууд. 8), 1929 оны 8-р сарын эхээр ирсэн зүүн хязгаарын мэдээнд, Хөлөнбуйр дэх Хятадын захиргаанаас тухайн газрын хошуу бүрээс хүмүүсийг цэрэгт татсан ба 1929 оны “7-р сарын

хоридоор 5000 адуу дайчилж дараагаар мөн 600 морь нэмж аваад одоо бас 600 морь бэлтгэх тухай тушааж” (Архив, хууд. 8) морь нэг бүрийн үнэд 120 янчаан олгож, цаашид адууг худалдаалахыг чангалан хорьжээ. Мэдээж Монголын аюулгүй байдалтай холбоотой энэ бүх мэдээллүүдийг ЗХУ-ын эрх баригчид албан болон албан бус шугамаар авч байсан нь лавтай бөгөөд энэ нь Зөвлөлт, Коминтерноос Монголын аюулгүй байдлыг анхаарч үзэхэд хүргэж байв.

Гэтэл энэ үед Япон улсаас Хятадын зүүн хойд муж, Өвөр Монголд нөлөөгөө өргөжүүлэхийг зорьж, үүний тулд 1920-иод оны сүүлчээс эхлэн зүүн хойд Хятад, Манжуур, Өвөр Монгол болон БНМАУ-ын эсрэг явуулах цэрэг тагнуулын ажиллагаагаа нэмэгдүүлэх болжээ (Г.Мягмарсамбуу, 2014, хууд. 147). Ийм үед Хятад, Японы зүгээс БНМАУ-д үзүүлж болзошгүй аюулын шинэ голомт Өвөр Монголд хэрэгжүүлж буй Банчин богдын үйл ажиллагаа нь БНМАУ-ын эсрэг аюул тээж байна гэж Коминтерн хийгээд Монголын нам, төрийн эрхэнд гарсан зүүний шинэ удирдагчдаас үзэх болов. Банчин богдын “аюул”-ын тухай мэдээг дээд удирдлагууддаа байнга өгч Коминтернд нөлөөлж байсан хүн бол Монгол дахь Коминтерний төлөөлөгч М.И.Амагаев болно.

1928 оны сүүлчээр хуралдсан МАХН-ын VII Их хурлаар баруунтны удирдагчдыг Монголын улс төрөөс хүчээр зайлуулсны дараа 1929 оны эхээр Коминтерний Дорнодын хэлтэс ба Алс Дорнодын Нарийн Бичгийн Дарга Нарын Газар (АДНБДНГ)-т болсон хурлуудад тусгайлан Монголын нөхцөл байдлыг гадаад, дотоодын хүчин зүйлтэй холбон үнэлж, “Монголын асуудал”-ыг хэд хэдэн удаа хэлэлцэв. 1929 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн хуралдаанд, Монгол орныг нөлөөнийхөө

хүрээнд байлгах тухай болон Монголд гаднаас үзүүлж буй аюулын асуудлыг хэлэлцэх үед Б.Шмераль хэлэхдээ: “Монголыг империалистууд хийгээд дэлхийн хувьсгалын дайсны нөлөөнд оруулахгүйн тулд бусармаг аргаар ч болов хичээх нь манай зорилт мөн” (Ч.Дашдаваа, 1996, хууд. 284) гэжээ. Мөн хурлаар Япон улс нь Хятадын зүүн хойд хэсэг болон Өвөр Монголд нэвтэрч, цаашид Гадаад Монголд тулгарч болзошгүй аюулын асуудлаар Мамаев¹ илтгэв. Мамевын дараа Монгол дахь Коминтерний төлөөлөгч М.Амагаев Монголын асуудлаар тавьсан тусгай илтгэлдээ, Монголд 1921 оны хувьсгалаас хойш МАХН-аас шашин, лам нарын талаар хэрэгжүүлж ирсэн бодлогод дүгнэлт өгч, эдүгээ “хар, шар феодал, хөрөнгөтний элементүүд”-ээс шинэ засгийн газрын эсрэг тэмцэл гаргаж болзошгүй байдал үүсээд байна, иймээс “...буддын шашны хувьсгалын эсэргүү дээд хэсгийн эсрэг тэмцэж эхлэх хэрэгтэй байна” (Ч.Дашдаваа, 1996, хууд. 284) гээд, энэ тухай үндэслэлээ “Хятад улс, ялангуяа Япон улс Монголын асуудлаар буурьтай оролдох болсон гэдгийг үг дуугүй хүлээн зөвшөөрч, зөвшөөрөхөөр үл барам үүнийг анхаарах хэрэгтэй... үүн дээр би нэг бодит баримт нэмж хэлэхэд Монголын хилийн дэргэд Банчин Богд ирсэн баримт юм. Банчин Богд Монголын хилээс 70 мод газрын зайд сууж байгаа. Тэр яах гэж тэнд очоо вэ? Банчин Богд ингэх тодорхой шалтгаан, тодорхой зорилго байгаа нь ил. Лам нарын дотор жаахан дургүйцэх явдал бий. Тэр дургүйцлийг ашиглах юм бол, түүнийг зохих ёсоор зохион байгуулах юм бол Монголд Афганистаныхтай адил хөдөлгөөн гарч болох юм” (Ч.Дашдаваа, 1996, хууд. 303) гэжээ.

Намын Төв Хорооны нарийн бичгийн даргаар шинээр сонгогдсон П.Гэндэн 1929 оны 2, 3-р сард Коминтерний шугамаар

¹ Мамаев Иван Карпович (1894-?) нь 1920-иод онд ажилчин, тариачин улаан армийн штабын ажилтан байсан ба Сун Ятсений нэрэмжит Хятадын хөдөлмөрчдийн коммунист их сургуульд багшилж байжээ.

Москвад айлчилж, энэ дагуу 2-р сарын 23-нд Коминтерний Улс Төрийн Нарийн Бичгийн Дарга Нарын Газар (УТНБДНГ)-ын хуралдаанд Монголын байдлын тухай илтгэл тавив. Тэрээр Монгол оронд гаднаас Хятад, Япон, Банчин богдын аюул, дотоодод баруунтны болон лам нарын гэсэн үндсэн хоёр аюул байна гэж тэмдэглээд, түүнтэй тэмцэх чухал зорилт эдүгээ МАХН-д тулгарч байгаа тухай илтгэлээ зориулжээ. Тэрээр хэлэхдээ, “БНМАУ-д заналхийлж байгаа гадаадын аюул нь зөвхөн Нанжины засгийн газрын түрэмгий бодлогоор хязгаарлагдахгүй”, Японоос “азитивийг азийнханд” гэдэг лоозон дэвшүүлэн Монголыг булаан эзлэх бодлогоо хэрэгжүүлэхийг хичээж байгаагаар улам ихсэж байна. Япон энэхүү явууллагадаа Жан Шүэлян², шашны төлөөлөгч Банчин Богд, мөн Монголоос дайжин зайлж Хятадад суугаа Монголын феодалууд болон Цагаантан нарыг ашиглаж байна. Тиймээс “эдгээр этгээд” бол Японы булаан эзлэгч бодлогыг явуулагчид мөн хэмээгээд, иймд нэгд, “улсын дотоод, гадаадад буй монголын феодалуудын хувьсгалын эсэргүү ажил явууллагыг илчлэх”, хоёрт, Японы зүгээс хийх аюул, ялангуяа Банчин богдод хандах Монголын сүсэгтэн олны санаа сэтгэлийг няцаахын тулд “буддын шашны хувьсгалын эсэргүү төлөөлөгч Банчин богдыг илчлэх” (Ч.Дашдаваа, 1996, хууд. 308), түүний хувьсгалын эсэргүү ажил явууллагыг илрүүлэх өргөн далайцтай ажил өрнүүлэх том зорилт тавьж байна гэж мэдэгдэв. Гэтэл тус хурал дээр П.Гэндэний илтгэлийг дүгнэж Коминтерний АДНБДНГ-ын эрхлэгч Миф³ хэлэхдээ: “нөхөр Гэндэн энд урвагчдын тухай, Монгол нутагт өдий төдий хувьсгалын эсэргүүчүүд үзэгдэх болсон тухай мэдээлж, энэ шугамаар Монголын хувьсгалын эсэргүүчүүдийн хийж байгаа бэлтгэлийн тухай ярилаа. Энэ

мэдээ тусгаар тогтносон Монголын цаашид оршин тогтнох явдалд бидний сэтгэлийг түгшээх ёстой... Үнэндээ гэхэд одоо Монголын хилээс 80 мод газар Банчин богд хүрч ирчихээд Монголд лам хувраг нарт тус оронд илүү дээд байдал, эд хөрөнгийн илүү байр суурь хангаж байсан хуучин журмыг сэргээхийн төлөө ухуулга хийж байна шүү дээ. Гаднаас занал хийж буй аюулыг хэрэгсэхгүй орхиж үл болно. Энэ асуудлыг буурь суурьтай анхаарч зохих арга хэмжээ авах хэрэгтэй” (Ч.Дашдаваа, 1996, хууд. 315) хэмээгээд нөхөр П.Гэндэнгийн илтгэлд үндэслэн тусгай тогтоолын төсөл оруулах нь зүйтэй гэж мэдэгдэв.

Энэ бүхний үр дүнд 1929 оны 3-р сарын 1-нд Коминтерний УТНБДНГ-аас Монголын асуудлаар 9 зүйл тусгай тогтоол буюу Монголын шинэ удирдлагад өгөх удирдамж заавар гаргав. Түүнд “БНМАУ-ын Ардын Хувьсгалт Нам нь Коммунист Интернационалд талархагч байгууллагын хувьд Коминтерний үзэл суртал, улс төрийн шууд удирдлагын дор ажиллана” (Ч.Дашдаваа, 1996, хууд. 317), Богд ба бусад хутагт хувилгаадын хойд дүрийг дахин тодруулж болохгүй, мөн Японы империализмд ашиглагдаж Монголын тусгаар тогтнолд дайсагнагч бүлгүүдээс (Банчин богд, Мэрсээ зэрэг) “Монголын ард түмнийг дайнд татан оруулах гэсэн өдөөн хатгах аливаа оролдлогыг хамгийн шийдвэртэй илчлэн тэмцэхийг МАХН-аас шаардаж байна” (Ч.Дашдаваа, 1996, хууд. 318) гэжээ. Энэ шийдвэрийг Коминтерний төлөөлөгч М.Амагаев Улаанбаатарт авч ирж хэрэгжүүлэх ажилдаа яаравчлан орсон юм. Эндээс үзэхэд, VIII Богдын хойд дүр Хятадад суугаа Банчин богдоор тодруулагдаж Монгол дахь Зөвлөлтийн нөлөөг устгахад чиглэсэн “пан Монгол” лоозон бүхий Японы бодлогод ашиглагдаж

2 Жан Шүэлян нь 1928 онд эцэг Жан Зуолиныг алагдсаны дараа 1928-1936 оны хооронд Хятадын зүүн хойд армийн удирдагчаар ажилласан.

3 Жинхэнэ нэр нь Фортус Михаил Александрович

болзошгүй хэмээн Коминтерний эрх баригчид үзэх болсныг илтгэнэ.

Коминтерний тогтоолыг Монголын тал хүлээн авч 1929 оны 9-р сарын 20-нд хуралдсан Улсын 14 дүгээр бага хурлын тогтоолд, Япон улс нь “Барга, Дотоод Монголын ван, гүнгүүд ба хувьсгалаас урвасан Мерсев, Төвөдөөс оргож ирсэн Банчин богд... Манжуур, Харбины зүгт үүрлэн байгаа хувьсгалын эсэргүү анги болох цагаантны этгээдэд ил, далд тусламжийг үзүүлж Монгол ба Холбоот улсуудын газрууд дээр үймээн будилаан гаргуулж, байлдааны хөдөлгөөнд оруулан холбогдуулахыг эрмэлзэх ба тус Монголын дотоод дахь хувьсгалын эсэргүү анги, барууны этгээд хийгээд хуучны шар, хар харгис феодал ба Монгол үндэстнийг нэгтгэнэ гэсэн харгис үзэлтэнд элдэв тусламжийг үзүүлэн өндийлгөж, дотоодын хувьсгалыг эсэргүүцэх хүчнийг зузаатгаж, манай улсын дотор самууруулах аргыг эрж оролдох гэж онц болгон явуулж” (Насанбалжир, 1956, хууд. 281) байна гэж мэдэгджээ.

Удалгүй 1929 оны 11-р сарын 9-нд Коминтерний төлөөлөгч М.Амагаев Коминтерний УТНБДНГ-н коллегийн хуралд “МАХН-ын дотоод байдлын тухай” хэмээх олон хуудас тайланг илтгэв. Тэрээр Монголд засгийн газрыг эсэргүүцсэн лам нар, түшмэд, баян чинээлэг хэсгээс идэвхтэй бодлого явуулж, ялангуяа тэд зохион байгуулалтын замд орсон хэмээн онцлоод, түүнд Банчин богд их үүрэг гүйцэтгэж байна гэж үзэж байгаагаа хэлэв. М.Амагаев илтгэлдээ: “Банчин богд Монголын хил орчим байнга сууж, тэндээсээ Монголын хувь заяаны тухай өөрийн тодорхой зорилго бүхий илгээлт, зөн лүндэнгээ эхний үед мянга мянган хувиар тарааж байв” (Ч.Дашдаваа, 1996, хууд. 323), агуулга нь “ариун буянт цэргийн тухай өгүүлж, сүсэгтэн бүр ариун дайнд оролцох ёстой. Мөн тэнд бурхан шашингүй... ЗСБНХУ-ын

эсрэг тийм ариун дайн хийнэ гэж өгүүлжээ. Тэрхүү илгээлтэд олон түмнийг дайчлах, байгууллага бэлтгэх, зэвсэгт бослого гаргах, зөвлөлтийн эсрэг тэмцэх утга санаа агуулагдаж байна” (Ч.Дашдаваа, 1996, хууд. 322) гээд эцэст нь гаднаас удирдаж байгаа энэ бүх ажил Монголд “...зэвсэгт бослого гаргахад бэлтгэх зорилготой” (Ч.Дашдаваа, 1996, хууд. 323) байна хэмээжээ. Гэвч М.Амагаев энэхүү илтгэлдээ Банчин богдын өдөөн хатгалгаар Монголд төрийн эсрэг зохион байгуулалттай “бүлэг” үүсээд байгаа тухай ямар ч баримт баталгаа гаргаагүй юм.

М.Амагаевын илтгэлийн дараахан 1929 оны 12-р сарын 4-нд Коминтерний ДНБДНГ-аас МАХН-ын Төв Хороонд Намын “8 дугаар Их хурлын өмнө тулгарч буй зорилтын тухай” хэмээх захидал ирүүлж, түүндээ Япон нь Монголын талаарх бодлогодоо Банчин богдыг хэрхэн ашиглаж байгаа тухай албан ёсны дүгнэлт гаргасан байв. Захидалд, “Япон улсаас Монголыг эзлэх явдлыг идэвхжүүлж байна. Баргын бослогыг өдөөн хатгасан, Дотоод Монголд явуулан буй идэвхтэй ажил, Банчин богдыг ашиглаж байгаа зэргийн явууллагууд болбоос Япон улс Монгол улсад нэвтрэн орж колони хараат байдалд оруулахыг шаргуу эрмэлзэж буйн гэрч тэмдэг мөн. Банчин богд болбоос хувьсгалт Монгол улсад ихээхэн аюул бүхий этгээд болой” (Ч.Дашдаваа, 1996, хууд. 347) хэмээгээд, цааш нь Япон улсаас Банчин богдыг ашиглаж түүний хүрээлэлд хувьсгалын эсэргүү ба гадаад, дотоодын үндэс угсааг баримталсан “аливаа үл бүтэх этгээд” (Ч.Дашдаваа, 1996, хууд. 347) нарыг нэгтгэн “шарын шашныг хамгаалагч Богд гэгээн тэргүүтэй Их Монгол улсыг байгуулна хэмээсэн уриан дор нийгмийн өргөн баазтай хувьсгалын эсэргүү хөдөлгөөн үүсгэх гэж оролдож буй амуй” (Ч.Дашдаваа, 1996, хууд. 347) гэжээ.

Ийнхүү Коминтерноос МАХН-д Банчин богдын тухай өгсөн улс төрийн

дүгнэлтүүдийг нэг бус удаа ирүүлсэний дотор Коминтернээс 1930 оны 12-р сарын 8-нд МАХН-д ирүүлсэн захидалд, “японы империалистуудаар удирдуулсан хятадын цэргийнхэн, Өвөр Монголын ноёд, Оросын цагаан армийнхан зэвсэглэсэн дээрэмчдийн бүлэглэлийг Монголын бүгд найрамдах улс руу нэвтрүүлэх зорилгоор идэвхтэй бэлтгэж байна. Үүнийг бэлтгэхэд өөрийн агент Банчин богдыг бүрэн ашиглаж байна” (Архив, хууд. 11-12) гэжээ. Коминтерн эдгээр дүгнэлтдээ баталгаа болох баримт гаргаагүй боловч энэ үед МАХН нь Коминтерноос ирүүлсэн бодлого, чиглэлийг шууд даган баримтлах болсныг илтгэнэ.

Ийнхүү МАХН-ын VIII Их хурлаар хэлэлцэх асуудал, тэр дундаа Банчин богд ба шашны асуудлаар гаргах бодлого, тогтоолын чиглэлийг Коминтерноос нэгэнт урьдаар ирүүлсэн байв. Тэр ч ёсоор 1930 оны эхээр хуралдсан (2.21-4.3-ны хооронд) Намын VIII Их хурлын тогтоолд Коминтерний захидлыг бараг шууд орчуулан тэмдэглэсэн байдаг. Тухайлбал, лам нарын доторх “ихээхэн харгис ангийн этгээд нараас эдүгээгийн засгийг унагаах бодлогыг тавьж хувьсгалд тэрслүү ажлыг явуулж буй нь Банчин богдтой холбоотой” байна. Иймээс “харгис лам нарын аливаа хувьсгалын тэрслүү явдлыг шуудаар тасална”(МАХН-ын түүхэнд холбогдох баримт бичгүүд, 1920-1940, 1966, хууд. 249-250). “Банчин богд бол хувьсгалын эсэргүү ангийн этгээд болохыг олон ардуудад тайлбарлан ухуулах” (МАХН-ын түүхэнд холбогдох баримт бичгүүд, 1920-1940, 1966, хууд. 243)-ыг нэн чухалчилна гэжээ.

Намын VIII Их хурлыг залгаад 1930 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр хуралдсан Улсын VI Их хурлаас гаргасан тогтоолд, Коминтерноос өмнө ирүүлсэн Банчин богдын тухай дүгнэлтийг давтахын зэрэгцээ, Япон улс, Банчин богд нь Монголд “...заавал улс төрийн хувьд өргөн үндэстэй хувьсгалд тэрслүү хөдөлгөөн

үүсгэх” (Ц.Насанбалжир, 1956, хууд. 125)-ийг оролдон байна хэмээн тэмдэглэв.

Дээр өгүүлсэн илтгэл, тогтоолуудаас үзвэл, Коминтерний эрх баригчид үзэхдээ, Япон улс нь “ази тивийг азийнханд” гэдэг лоозон дор БНМАУ-ыг эзлэх зорилго тавьж, улмаар Банчин богд, Жан Шүэлян, Цагаантан, Өвөр Монголын феодал ван, гүн нар болон хувьсгалаас урвагч Мэрсээ нарт тусламж үзүүлж ЗХУ болон Монголыг өөрийнхөө эсрэг гаднаас дайн өдүүлэх эсвэл Монгол дахь баруунтны этгээд хийгээд хуучны хар, шар феодал, үндсэрхэг үзэлтнүүдийг дэмжиж дотроос нь БНМАУ-д засгийн газрыг эсэргүүцсэн бослого гаргах гэсэн хоёр аргаар оролдож байгаа бөгөөд гагцхүү энэ хоёр аюулын гол холбогч, “нэгтгэн бөөгнөрүүлэгч” (Ч.Дашдаваа, 1996, хууд. 347) нь Банчин богд хэмээн дүгнэжээ.

Үүнээс хойш Япон, Банчин богдтой тогтоосон холбоо, сүлбээг илчлэх (Ч.Дашдаваа, 1996, хууд. 305) нэрээр Зөвлөлтөөс хүмүүсийг улс төрийн хэрэгт холбогдуулан яллахдаа Зөвлөлт, Монголын дотоодод Буриадуудыг цагаантны үлдэгдэл хэмээн тулгаж, харин Монголчуудыг Японы гар хөл болж хувьсгалын эсэргүү хэрэг өдүүлэхийг санаархсан, эсвэл өдүүлсэн хэмээн гүтгэн шийтгэж байсан бол, хилийн гадна Өвөр Монголчуудыг, ялангуяа Баргын бослогын удирдагчдыг Монгол овогтныг нэгтгэх үзлээр Японы талд үйлчилж Зөвлөлт, Монголыг гаднаас нь өдөөн хатгаж зэвсэгт мөргөлдөөнд татан оруулах зорилгоор ажилласан хэмээн буруутгах болсон нь тэдний дээрх дүгнэлтийнхээ дагуу хэрэгжүүлсэн ажил болох нь харагддаг. Тухайлбал, Мэрсээ болон Банчин богдын хооронд 1920-иод оны сүүлчээс ойр харилцаа тогтож, 1929 оны үед Мэрсээ нэг хэсэг Банчин богдын зөвлөх хийж (阿。恩克巴图, 额尔很巴亚尔, 1985年, , 第126页), 1931 онд Банчин богд Иргэний засгийн газрын Нанжинд

болсон хуралд оролцсоны дараа тус оны 7-р сард Хөлөнбуйрын төлөөлөгчдийн бүлгэмээс Нанжинд очиж Банчин богдыг тосож Хөлөн буйрт аваачихад Мэрсээ цуг явж (那木海扎布, 1988年, 第196页), улмаар Банчин богдын Хөлөнбуйрт байх хугацаанд тэд харилцаатай байжээ. Иймд Зөвлөлтийн эрх баригчид Мэрсээг Банчин богдоор дамжуулан Японы дэмжлэгийг олж Банчин богдын нэр нөлөөг ашиглан нэгдсэн Монгол улс байгуулах үзлээр Зөвлөлтийн эсрэг босох аюултай хүн хэмээн сэжиглэх болсон бололтой. Тиймээс 1931 оны 12 дугаар сарын 11-ны өдөр Мэрсээг Манжуур дахь Зөвлөлт Холбоот Улсын консулын газарт очиход нь баривчлан хил давуулж, Зөвлөлтөд яллахдаа “Японы тагнуулын газарт тагнуул хийсэн, зэвсэгт бослогод бэлтгэсэн, зэвсэгт мөргөлдөөнд өдөөн хатгахыг оролдсон” (Д.Наранжаргал, 2014, хууд. 53) гэж буруутгажээ.

Зөвлөлт, Коминтерний эрх баригчид Японы зүүн хойд азид чиглэсэн цэрэг, стратегийн бодлогыг Монголд холбогдуулан дүгнэхдээ, БНМАУ-д дотоод, гадаадын дайсагнагчдын аюул нүүрлэсэн түгшүүртэй үе ирлээ гэж мэдэгдээд, тэрхүү “аюул”-ыг илчлэх нэрээр монголд улс төрийн хэлмэгдүүлэлт явуулахыг шаардсан гэж хэлж болно. Үүний цаана нэг талаар, ЗХУ-аас хаалттай орон байлгах бодлого байсан гэдгийг огт үгүйсгэхгүй ч, нөгөө талаар Зөвлөлт Их гүрнээс Монгол дахь байр сууриа авч үлдэх, Монголыг нөлөөнийхөө хүрээнд найдвартай барьж байх гэсэн улс төр, геополитикийн том бодлого оршиж байв. Ийнхүү Монгол дахь улс төрийн хүчирхийлэл цаашид Японы тагнуул, Банчин богдын хань хамсаатныг “илчлэх” нэрийн дор хэрэгжих болсон юм.

Хоёр. Банчин богдын эсрэг Өвөр Монголд хэрэгжүүлсэн зарим суртал ухуулгын материалын агуулга

Япон улс нь зүүн хойд Азид чиглэсэн бодлогоо илт идэвхижүүлж ирэхэд Монгол

дахь Зөвлөлтийн байр суурь хөндөгдөх болов. Энэ үед Зөвлөлт, Хятад аль аль нь Японы бодлогыг сөрөх, зогсоох бэлтгэл хангагдаагүй тул Японыг харлуулах хирээр өөрийн аюулгүй байдлыг хангаж, цаг хожих болов. Иймд ЗХУ-аас Монголыг нөлөөндөө бүрэн оруулахын тулд гадны аюулаар айлган олон түмнийг итгэж үнэмштэл, зөв бурууг ялгахын аргагүй болтол сэтгэл зүйн довтолгоог хийж эхэлсэн юм (Д.Дашдулам, 2017, хууд. 154). Гадаад аюулын тухай үзэл суртлын гол дайралт нь Японы түрэмгийлэл азид тэр дундаа Монгол, Хятадыг “залгина”, Япон нь Зөвлөлт, Монголын эсрэг тэмцлээ Банчин богд тэргүүтэй гадаад, дотоодын эсэргүү хүчинд тулгуурлаж байна хэмээсэн мэдэгдлийг Коминтерноор дамжуулан Зөвлөлтөөс идэвхитэй хийж эхлэв.



Зураг 1 “Банчин богдын тухай ухуулах бичиг” нэрт товхимлын хавтасны зураг.

Ийнхүү Коминтерн болон ДМАХН-аас Япон ба Банчин богдын харилцааг “илчилж”, Банчин богдын Монголын ард түмэнд үзүүлэх нөлөөг таслах, түүний “аюул”-ыг өргөн олонд нэвтрүүлэх суртал ухуулгын ажлыг өргөн далайцтай хийж эхэлсэн юм. Ингэхдээ суртал ухуулгыг зөвхөн БНМАУ төдийгүй Өвөр Монголын хувьсгалчдын үйл ажиллагаанд ч тусган хэрэгжүүлж эхэлжээ. Учир нь Монголд Япон ба Банчин богдын эсрэг ухуулгыг хүчтэй явуулах болсон 1920-иод оны сүүл

үетэй зэрэгцэн тэдгээртэй ижил агуулгатай мэдэгдлийг Дотоод Монголын Ардын хувьсгалт нам (ДМАХН)-аас явуулах болжээ. Энэ тухай зарим баримтыг авч үзье. Үүнд, ДМАХН-ын шинэ төв хорооноос тусгайлан “Банчин богдын тухай ухуулах бичиг” гэсэн нэртэй жижиг товхимлыг 1929 оны 7-р сарын 1-нд Долоннуурт хэвлэн тархаасан байна. Товхимолд өгүүлэхдээ, Япончууд Банчин богдыг улс төрийн бодлогодоо ашиглаж байна хэмээн үзээд, энэ тухай “Япон улсаас Банчин богдыг ихэд хүндэтгэн, Монгол, Япон болбоос шашин нэгтэй бөгөөд цөм азийн шар арьстан болох тул Япон улсаас манай Монголын бурхны шашныг дэлгэрүүлэх, эрх чөлөөгөө тэмцэх явдалд туслалцаж, бүх Монгол угсаатныг нэгтгэмүй... хэмээсэн хуурамч заль арга явуулан хувьсгалын эрх чөлөөгөө олсон гадаад Монгол улсад халдах санаатайгаар оролдон буй... одоогийн Банчин богдын эл үйлдэж бүхүй хэрэг цөм түүний ард бүхүй эзэрхэг Япон ба Хятад нарын Монголыг хорлох явдал мөн” гээд энэ бүхэн нь Япон улсаас “хөхи-д идэш хийж загасыг барих мэт Банчин богдоор бамбай хийж шашны нэрийг ашиглан Монголын ард түмнийг мэхэлж, чухамхүү манай саруул сайхан уудам нутаг орныг булаан эзлэх үндэс угсааг сөнөөх туйлын хорт бодлого даруй мөн болмуй”(Банчин богдын тухай ухуулах бичиг, Долоннуур, 1929, хууд. 5; Төв, хууд.5) гэжээ. Товхимолд, 1926 оноос Жан Зуолин Банчин богдыг Мүгдэнд суулган ашиглах болсонд дургүйцэж “...Хятадын эзэрхэг цэргийн эрхтнээс Мүгдэн хотноо Монгол Төвөдийн Хэрэг Шийтгэх Газар байгуулж Банчин богдоор дарга болгон, түүний дэргэд цэргийн ба сан татварын зэрэг гурван хэлтэс байгуулж бас Банчин богдын биеийг хятад цэргээр хамгаалан Жирэм ба Шилийн гол зэрэг чуулганд залруулан явуулж зарим дор Мүгдэн, Бээжин, Нанжин зэрэг хотод авчирч их хүндлэх боловч мөн ч хуучин Манжийн Монголын сүр хүчнийг бууруулж Монгол тоотныг бүрмөсөн гар

хөлийн доор оруулан авсан бодлогыг хэвээр мөрдөн хэрэглэж” (Банчин богдын тухай ухуулах бичиг, Долоннуур, 1929, хууд. 7) байна гэжээ.

Мөн цааш нь, Япон болон Гоминданы Хятадаас Банчин богдыг дараах гурван талаар ашиглаж Өвөр Монголыг түрэмгийлж, монголын үндэс язгуурыг балруулахаар оролдон байна хэмээн дурдан гаргажээ. Үүнд нэгд, “эдүгээ Банчин богдын нэрийг зээлдэн элдэв зүйлийн лүндэн мэтийг тархааж Монголын ард түмний сэтгэл санааг үймүүлэн” байна. хоёрт, “Банчин богдын нэрээр Монгол газар цэрэг байгуулан Монголын газар нутгийг эзэрхийлэх”, гуравт, “Банчин богдын дэргэд сан татварын хэлтэс байгуулж Монголын эд ашгийг хуралдуулан үүгээр Монголын үндсэнд хор хүргэх явдлыг бүтээх зэрэг туйлын хорт бодлогыг нэгэн зэргээр явуулж буй бөлгөө” гэжээ. Төгсгөлд нь, иймээс Банчин богд бол “гадаадын эзэрхэг дайсан этгээдийн хүйтэн гарыг зээлдэн шашин, төрийг балруулах, ард амьтныг сөнөөх явдлыг үйлдэх зэвсэг болсноор үл барам... эзэрхэг Япон ба Хятад нар лугаа нэгэн замаар оролдож буй нь маш илэрхий болох учир... маш болгоомжлон сэргийлбээс зохино” (Банчин богдын тухай ухуулах бичиг, Долоннуур, 1929, хууд. 7) хэмээн бичжээ.

Энд дурдсан зүйлс нь нэг талаар, Япон болон Гоминданы үзүүлж буй бодитой дарамтыг эсэргүүцсэн Өвөр Монголын хувьсгалчдын үг, мөн тэдний зүгээс тухайн үед Банчин богдыг хэрхэн үзэж байсныг ойлгох мэдээ баримт мөн юм. Гэвч нөгөө талаар, Банчин богдын үйл ажиллагааг Япон ба Гоминданы Хятадын эзэрхийлэх бодлоготой нэгэн зэрэг холбон үнэлсэн нь үндсэндээ Коминтерн болон МАХН-аас Банчин богдын тухайд өгсөн урьдын болон хожмын мэдэгдлүүдтэй нийцэж байгааг анхаарууштай. Хожим НТХ-ны дарга асан Ц.Дамбадоржийн Орост байх үедээ орчуулж 1933 онд Ленинград хэвлэсэн зохиолч

Ван Мины “Манжуур дахь байдал хийгээд Японоос Хятад ба Монголыг шинэ довтлон халдах тухай” хэмээх бэсрэг номд, Японы зүүн хойд азид хэрэгжүүлж буй бодлого ба Манжуур дахь нөхцөл байдлыг дүгнэн бичээд, цаашид Японы эсрэг хэрэгжүүлэх бодлогын Өвөр Монголд гаргах тусгай лоозонд “Японы империалист нар Монголын ардыг боолчлоход тусалж бүхий Банчин ламын урвагч бодлогыг эсэргүүцэн тэмцэж” (Ван Мин, 1933, хууд.73)ухуулах явдлыг бичсэн буй.

“Банчин богдын тухай ухуулах бичиг”-тэй ижил агуулгатай нэг баримт бол ДМАХН-ын Төв хорооны “Цахарын төлөөлөгчдийн товчоо”-ноос тус Намын Төв хороонд 1930 оны 6-р сарын 20-нд бичсэн илтгэлд юм. Түүнд Хятадын Гоминдан нам болон Япон улсын түрэмгий бодлогод өртөгдөөд буй Өвөр Монголын Цахар хошуудын нийгэм, улс төр, эдийн засгийн байдал, ялангуяа Мүгдэн төвтэй Хятадын зүүн хойдын цэргийн удирдагчид болон Японы зүгээс Банчин богдыг ашиглан ямар ямар үйл ажиллагаа явуулж буй талаар тодорхойлон бичжээ. Тус илтгэлд, “Япон эзэрхэг... ялангуяа зүүн хойд этгээдээс Банчин богдыг ашиглан хэрэглэж Шилийн голын чуулгадаар жил шахам тойрон ажил хийсэн ба эдүгээ тэрхүү ажлын боловсрол нь илэрч өнгөрсөн жилийн (1929 он) 10, 11-р сард хэд хэдэн мянган зэвсэг ба өдий төдий үхэр бууг Баруун сөнөд ба Дөрвөд зэргийн хошуудад олгон өгч үүгээр зууч болгон Шилийн гол ба Улаанцавын олон ван гүн нар лугаа гар барилцаж, түүний (Япон улсын) Их Ази тив ба Их Монголын зорилгоо явуулахаа улам шамдан оролдсоор буй”(Төв, хууд. 23) гэжээ. Цааш нь, Мүгдэний цэргийн эрхтнүүдээс Өвөр Монголын ван, гүн ноёдыг өөртөө татан өндөр зэргийн эрх тушаал өгч улааныг цэвэрлэх түшмэл сайд болгон тус орон нутгийн хувьсгалын хөдөлгөөнийг дарах, хувьсгалч залуучуудыг барьж хорихын

зэрэгцээ Банчин богд болон Зодовжав, Самдандонров (Самданлхүнрүв) ноёдоос тэргүүлэн “Монгол цэрэг элсэж гадаад Монгол улсыг дайлаар одох явдлыг туйлын чухал болгон оролдож буй”(Төв, хууд. 23) гэжээ. Үүнийхээ нотолгоонд, амбан Зодовжав 1928 онд харьяат хошуунаас цэрэг цуглуулж, майхан, тогоо зэргийн цэргийн рэгсэл бэлтгэж байсан, мөн урьд нууцаар хил нэвтрэн Дарьганга нутгаас агт адууг хөөн ирсэн гэж бичжээ. Илтгэлд мөн, Зүүн хойд этгээдээс Банчин богдыг Шилийн голын чуулганд ирүүлж “ардын мухар сүсгийг ашиглан нийт арван түмэн адуу малыг бадарчлан авч чинагш Мүгдэн хотноо аваачиж мөнгөний хоршоо нээсэн”, энэ мэт Шилийн голын олон хошуудтай харилцаа байгуулахыг оролдож байгаа нь Өвөр Монголд эдийн засгийн хүчээ нэвтрүүлэн бататгахын төлөө юм хэмээжээ.

Дашрамд дурдахад, тухайн үед Банчин богдод зэвсгийн хэрэгцээ гарсан нь үнэн авч тэдгээр зэвсгүүдийг БНМАУ-ын эсрэг бус, харин Непалын эсрэг хэрэглэхэд зориулж байжээ. Учир нь 1930 оны хавар Непал, Төвөдийн хооронд зөрчил үүсэж, Непалаас Төвд рүү халджээ. Непалын энэ үйлдлийн цаана Англи улс байсан гэж зарим судлаачид үздэг. Энэ мэдээг Банчин богд сонсмогцоо Бээжин дэх Монгол-Төвөдийн хороонд захиа бичиж, Гоминданы засгийн газарт дараах шаардлагыг тавьсан байна. Үүнд “Төвөдийг Непал ихээр дайран довтолсон учир, сэргийлэн хамгаалах цэрэг байгуулж Төвөдөд орохыг зөвшөөрч, буу таван мянга, сум хоёр сая таван зуу, цэргийн хувцас таван мянга, цэргийн цалин хүнсэнд сарын нэг зуун мянган юань” (九世班禅内地活动及返藏受阻档案选编, 1992年) олгохыг хүсжээ. Энэ нь түүний Төвөддөө буцах чин хүслийг биелүүлэх боломж байв. Гэвч тус оны 6 дугаар сард Баруун Кам Ганзи (Төвөдийн автономитын нийслэл буюу одоогийн Си Чуань) болон Хөхнуур, Жинчуан зэрэг газарт засаг захиргаа

хооронд үүссэн тэмцлийн улмаас Банчин богдын нутаг буцах асуудал мухардалд оржээ⁴. Гэсэн ч тэрээр энэ үед Төвд болон Кам дахь зөрчилдөөнийг шийдвэрлэх, хил хязгаарын асуудлыг цэгцлэх зэрэг Төвөдтэй холбоотой дотоодын асуудалдаа ихээхэн анхаарч байсан юм.



Зураг 2. Монголчуудын Банчин богдод өргөсөн өргөл Японы түрэмгийллийн эдийн засгийн нэгэн үндэс болж байгаа тухай харуулсан зурагт хуудас өргөн 72 см, өндөр нь 54 см).

Зургийн эх Монголын Үндэсний Музейн сан хөмрөгт хадгалагдаж буй. Ж.Болдбаатар. XX зууны Монгол Улс. Шилдэг үзмэрийн дээжис. 1921-1952. УБ., 2017, т.66.

Мүгдэний эрх баригчидтай холбоотой Банчин богдыг тухайн үед Хятадын зүүн хэсэгт хүчин төвлөрч Өвөр Монголд нөлөө эрхшээлээ тэлж байсан Японы бодлоготой холбож үзэх нь зүйн хэрэг. Гэвч Цахарын төлөөлөгчдийн товчоо бол Дотоод Монголын Ардын Хувьсгалт намын хагарлын дараа тус намын 1927 оны 8-р сард Улаанбаатарт хуралдсан тусгай их хурлаас сонгогдсон Намын шинэ төв хорооноос Өвөр Монголд томилсон төлөөлөгчдийн үүсгэн байгуулсан хувьсгалт байгууллага юм (Цолмон, 2019, хууд. 55). Энэ утгаараа тус товчооны үйл ажиллагаа нь эцсийн дүндээ Зөвлөлт, Коминтерний Өвөр Монгол дахь хувьсгалын бодлогод захирагдаж байсан юм.


1920-иод оны сүүлч, 30-иад оны эхээр БНМАУ болон Өвөр Монголд тархаасан хэд хэдэн ухуулах зурагт хуудаст Банчин богдыг дүрсэлсэн байна. Тухайлбал, 1930-аад оны эхэн үед гаргаж Өвөр Монголд тараасан энэ үзүүлэнбуй зурагт хуудаст тусгайлан Банчин богдыг Японд хүчин зүтгэж байгаагаар дүрсэлжээ. Зургийн өгүүлэмжийг үзвэл, Банчин богдыг дүрслэн зурж, түүний улаан өнгөтэй орхимжийн баруун гар дээр “Төвөдийн оргодол Банчин” хэмээн монголоор бичжээ. Улмаар Банчин богд нь сүсэгтэн монголчуудын өргөл барьцыг урт хумст хоёр гараараа том ангайсан ам уруугаа хаман оруулж, тэрхүү эд баялагийг мөнгө болгон, түүнийг нь зөөж буй хятад хүмүүсийг “дотоод Монголын феодал” хэмээн бичсэн нэгэн ноён Банчин богдын хормойг сөхөн гаргаж, улмаар нэгэн цэргийн хувцастай хүн эд бараа зөөгчдийг Японы ам уруу зааварлан оруулж, эцэст нь эдгээр шат дамжлагыг дамжаад Банчин богдод өргөсөн Монголчуудын өргөлийн хөрөнгөөр Япон улсаас эргээд Өвөр Монголын нутагт төмөр зам тавьж, түүгээрээ байлдааны буу зэвсэг тээвэрлэн авчирч газар нутаг, ард олныг нь эзэрхийлэн давшиж буй байдлыг дүрслэн үзүүлсэн байна. Мөн тус зурагт хуудасны доод талд бичсэн тайлбарт, “нэг хангах хэмээн залбирах харанхуй сүсэг бишрэлийн мөргөл өргөл болбоос шар хувалз харгис Банчины мөлжилтөөр хар ирвэс Хятад, Японы идэш болж гал машины хүчээр хөдлөх дайн байлдааны далайд унагааж дарийн утааны мананд төөрөгдүүлэхийг бэлтгэн баймуй. Үүнийг барга ба дотоод Монголын малчин олон ардууд та бүхэн сайтар танин мэдэх хэрэгтэй буй за. Таны энэхүү өргөл мөргөлөөр гайхал Банчин юуг үйлдэж буйг үүнээс үлгэрлэн үзвээс тодорхой амуй” хэмээсэн үгийг бичжээ.

Хятад оронд ямар ч үнээр хамаагүй империализмын эсрэг хувьсгалыг ялуулах

4 陈柏薄：《九世班禅在内地的政教活动述略》，青海：青海民族大学学报(社会科学版)，第2期，2012年4月，页-37。

зорилготой байсан Зөвлөлтийн хувьсгалын бодлогыг мухардалд хүргэсэн 1927 оны Хятадын Коммунист намын ялагдлын дараа, БНМАУ дахь Зөвлөлтийн байр суурьд аюул учруулж болзошгүй империалист Японы түрэмгийллийг урьдчилан Өвөр Монголд эсэргүүцэх чухал шаардлага Зөвлөлт, Коминтерний эрх баригчдын өмнө тулгарч ирсэн нь дамжиггүй. Иймээс энэ ажлыг гүйцэтгэх гол үүргийг ДМАХН-д тохоосон учир Банчин богдыг Гоминданы Хятад болон Японы бодлоготой холбон харлуулах суртал ухуулга Өвөр Монголын хувьсгалчдын гүйцэтгэх ажлын нэг чухал зорилт болсон бололтой.

Гурав. Банчин богдын эсрэг Монголд хэрэгжүүлсэн суртал ухуулгын зарим материалын агуулга



Зураг 3. БНМАУ “дайсагнагчдын хүрээлэлд” зурагт хуудас (1931 он).

С.Л.Кузьмин. Ж.Оюунчимэг. Социализмын эсрэг 1932 оны Монгол дахь бослого. УБ., 2014. т.231.

1931 онд гаргаж тараасан “Социализмын замаар явж буй БНМАУ “дайсагнагчдын хүрээлэлд” нэрт зурагт хуудаст дорно зүгт төвлөрөн байгаа Япон болон Оросын цагаантан, Өвөр Монголын ноёдын хамт Банчин богдыг өвөр Монголд сууж байгаагаар тод дүрслэн зурж, үүгээр БНМАУ-д “дайсагнагч” гадаадын хүчнүүд болон тэдний хорт бодлогыг хүн бүр сайтар таньж, болгоомжлон сэргийлэхийг дүрслэн ухуулсан байна.

1930 онд Дотоод Хэргийн Газраас Эрэгдэндагва нарын 38 хүний хэргийн тухай шүүх хурлыг олны өмнө ил тод, сүр дуулиантайгаар таслан шийтгэж, гэм зэмгүй олон хүнийг хэлмэгдүүлсэн билээ. Дотоод хэргийн газраас Банчин богтой холбогдох анхны том хэргийн сэжүүр, сэдэв шалтгийг олж, нэгэн “зохиомол хэргийг үнэн болгож”(Г.Мягмарсамбуу, 2014, хууд. 157) шийтгэсэн нь хувьсгалын эсэргүү тайж “Эрэгдэндагва нарын 38-ын хэрэг” гэгч байв. Хэргийг таслан шийтгэсэн тогтоолоос үзвэл, хутагт хувилгаад, ван, гүн, хуучны түшмэд, мяндаг хэргэм бүхий лам нар нийлж 1929 оны намраас эхлэн хувьсгалт засаг төрд тэрсэлсэн “эсэргүү бүлгэм” гэгчийг байгуулсан гэнэ. Улмаар “Хятадын гол засгийн газар ба Японы тагнуулчин Банчин нарт нэр хамтлан” (Ц.Насанбалжир, 1956, хууд. 122) тусламж гуйсан өргөх бичиг үйлдэж төлөөлөгч Эрэгдэндагваар илгээн явуулж байгаад илрэн баригджээ. Гэвч “үүнийг шалгаж үзвэл Б.Эрэгдэндагва ардын засгийг устгах эсэргүү бүлгэм байгуулаагүй. Харин тийм утгатай захиа бичсэн”(О.Одбаяр, 2012, хууд. 79) нь тодорхой байна. Энэхүү захидалд (С.Пүрэвжав, 1965, 131-132) Монгол Улсыг Дундад Иргэн улсын нэгэн муж болгон, Банчин богдыг урин залж есдүгээр Богдыг тодруулж хуучны ёсыг эргүүлэн тогтоохыг илэрхийлсэн ажээ. Эрэгдэндагва болон бусад холбогдох “хэрэгтнүүд”-ийг Дотоод Хэргийн Газраас 1930 оны 5 дугаар сараас баривчлан мөрдлөг явуулж тус оны 9 дүгээр сарын 28-нд Улсын Ерөнхий Шүүх таслах газрын өргөтгөсөн хурлаар тайж Эрэгдэндагва, Егүзэр хутагт Галсандаш, гүн Гомбо-Идшин, гавж Бүүвэй, зайсан түшмэл Чадарбал, Донойжав, Ишлодон нарын 7 хүнд буудан алах ял, Манзушир хутагт, Дилав хутагт, Чойнзин цорж зэрэг бусад 29 хүнийг ангийн ялгаврыг баримталж тэнсэн харгалзахаас 10 жил хорих хүртэлх ял оноож, 2 хүнийг суллан, буудах ялтай болон 10 жилээр

хоригдогсдын хөрөнгийг хураахаар баталж, яллан шийтгэжээ (Ц.Насанбалжир, 1956, хууд. 122-125). Тэдэнд шийтгэлийг маш хатуу оноож байсны нэг жишээ бол Бүүвэй гавжаас юу хийх гэж буйгаа хэлэлгүйгээр “үүсгэх гэж буй үйл бүтэх үү?” гэж Чойнзин цоржоос асуухад нь, цорж түүнд шоо орхин мэргэлж өгсөн гэх үндэслэлээр Чойнжин цоржид 10 жилийн хорих ял оноосон байна (Л.Чойжилсүрэн, 2000, хууд.223).

Эрэгдэндагвын хэрэгт шийтгүүлсэн 38 хүнээс феодал түшмэл 13, лам 14, хар болсон лам 4, ард 7 (Б.Дашцэвэг, 1976, хууд. 157) байсан гэдэг баримт бол Монголд Банчин богдтой холбоо тогтоосон шашны нөлөө бүхий хүн, Богдын хойд дүрийг тодруулж, хуучны ёсыг тогтоохыг хүсэгч шар харгис лам нар, мөн хувьсгалт засгийг эсэргүүцэж гаднаас тусламж эрэгч хуучны феодал зэрэг “аливаа үл бүтэх” (Ч.Дашдаваа, 1996, хууд. 347) этгээдээр хүрээлсэн Банчины Монгол дахь “аюул” гэж Коминтерноо дүгнэгдэгсэд энэ хэрэгт бүгд багтсан нь санамсаргүй хэрэг огт биш гэлтэй.

Тиймээс бид энд Эрэгдэндагвын хэрэгт холбогдуулан тархаасан нэгэн ухуулах бичгийг авч үзэх гэсэн билээ. Эрэгдэндагвын хэрэгт холбогдогчдыг баривчлан мөрдлөг явуулж эхлэхтэй зэрэгцэн нам, засгаас шашны эсрэг намын үзэл суртлын ажлыг хүчтэй өрнүүлж, түүндээ шашны өндөр нэр хүндтэй зүтгэлтнүүдийг татан ажиллуулах болжээ. Эхний удаа Гандан хүрээний их хамба Лувсанхаймчиг, дэд хамба Дамдин, Шашны Захиргааны дарга аграмба Гомбожав нарын өөрсдийн гарын үсэгтэй нэгэн ухуулах дэвтрийг (Гандан Хүрээний Шашны Захиргааны газраас тус шашны ядуу, дунд, ангийн лам нарт ухуулан зарлах бичиг, 1930) 1930 оны 5-р сард Гандан, Зүүн Хүрээний Шашны Захиргааны газраас гаргаж олон хувь хэвлэн тархаажээ. Түүнд бичсэнээр, урьд гарсан Баянтүмэн, Намнан уулын хошууны лам нарын хөдөлгөөн болон Саж лам, хувилгаан Жалцандамба

(Улсын 6 дугаар Их хурлын илтгэл, 1930, хууд. 70), Зая Бандидын зэрэг нарыг улсын хуулиар “хатуу чанга цээрлүүлэн шийтгэж олонд үзэмж болгосон нь үнэхээрийн зүйтэй” болжээ гээд “энэхүү хувьсгалд сөргүү хөдөлгөөн нь хэрхвээс хоосон ядуу ба дунд лам нарын хөдөлгөөн бус бөгөөд Банчин богдын зүгээс хатгалтай бөлгөө. Банчин богд болбоос Төвөд орноосоо оргон зайлсхийж Хятадын цэргийн эрхтэн ба Японы хөрөнгөтөнд биеэ худалдаж тэдгээрийн зарц гар хөл болсон бөгөөд Японы хөрөнгөтөн ба Хятадын цэргийн эрхтэн болбоос Банчин Богдын хамт Монгол улсын бүрэн эрхийг устгаж, Япон, Хятад зэргийн гадаадын эзэрхэг шунахай нарын гарт оруулахыг оролдмуй. Жич: Бидний Монгол бүрэн эрхгүйгээр шашныг мандуулж үл болох тул тэрхүү санамсаргүй эсэргүүцэн босогчид нь бидний шашны дайсан даруй болжээ... тус Шашны Захиргаа нь Ардын засгийг эсэргүүцэгчид бүхнийг хорт дайсан хэмээн үзэж эрс тэрсээр тэмцэх бөгөөд арваалж хорхой мэт авирлагч нарт амьсгалыг өгөгч Банчин Богдыг эрс тэрсээр эсэргүүцэн тэмцэх болмуй. Монгол Улсын ашиг тусыг Япон, Хятадын харгисуудад худалдагч нар бүгдээр сөнөтүгэй” (Төв, 31-33) гэж зарлажээ.

Ухуулах бичгийн агуулгаас үзвэл, дээд ангийн лам нар бол эх орныхоо эрх ашгийг гадны улсад худалдагчид төдийгүй Монголд өмнө гарч байсан лам нартай холбогдох бараг бүхий л хэргүүдийг тэд үйлдсэн бөгөөд, чухам цаад гол эзэн нь Банчин богд байсан гэжээ. Тиймээс Банчин богд бол Монголын төр хийгээд шашин, төрийн бүрэн эрх, шашны хөгжилд хоёуланд дайсагнагч этгээд мөн хэмээн зарлаж, түүндээ өргөн олныг итгүүлж, Банчин богд ба сүсэгтэн олны холбоог тасалж хөндийрүүлэх, нэр алдартай хутагт хувилгаад, ноёд тайж нарыг Банчин богдтой нэр холбон тэднийг Япон, Хятадын гар хөл мэтээр харуулан, хэлмэгдүүлэхэд

чиглэжээ. Энэ бол Монголын лам нарын толгой дээр нэлээд дээрээс шидүүлсэн чулуу байв. Түүнийг батлахын тулд ухуулах бичгийг түүхэн үйл явдлын ба учир зүй, цаг хугацааны гэсэн гурван талын уялдаа холбоонд нь авч үзье.

Түүхэн үйл явдлын хувьд, энд ухуулан сурталчилсан бүхэн бидний эхний хэсэгт өгүүлсэн Коминтерноос лам нар ба Банчин богдын талаар Монголын удирдлагад 1929 онд ирүүлсэн хэд хэдэн заавар, ялангуяа Коминтерноос 1929 оны 12-р сарын 4-нд Намын төв хороонд ирүүлсэн мэдэгдлийн агуулгыг шууд давтсан байгаа юм. Тиймээс энэ мэдэгдлийг Гандан хүрээнд тулган зөвшөөрүүлж, шашны өөрийнх нь зүгээс нийт сүсэгтэн олонд ухуулсан мэдэгдэл хийлгэжээ.

Харин учир зүйн хувьд, ухуулах бичгийг Гандан хүрээний удирдлагуудаар батламжлуулж гаргуулсан нь нэг талаар, Гандан бол Монголын бурхан шашны төв(Төр, шашны хэргийг тусгаарлан явуулах тухайн дүрэм, 1926; Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхтгэл, 1926, хууд.), нөгөө талаар их хамба Лувсанхаймчиг бол есдүгээр Банчин богдын зарлиг ёсоор Монголд ирж 8 дугаар Богд Жавзандамын ёнзин багш болж, Гандан Их хүрээний Хамба Номун ханд өргөмжлөгдөн сууж, улмаар Богд хааныг таалал төгссөнөөс (1924 оноос) хойш Монголын бурхны шашныг тэргүүлэх болсон шашны өндөр албан тушаалтай хүн байсан тул түүнийг зориуд сонгон хэрэглэжээ. Харин Лувсанхаймчиг бээр гэлэн сахилтай хувраг хүн атлаа энэ удаа багш шавийн хүнд журмыг умартан өөрийн зарлигийн багш Төвөдийн дээд лам Банчин богдыг одоо Монголын төр болон бидний шашны заналт дайсан нэгэнт болсон хэмээн хар, шар олноо албан

ёсоор мэдэгдсэн нь өөрийн сайн дураас үйлдсэн байх боломжгүй юм. Магадгүй Эрэгдэндагвын хэрэгт Лувсанхаймчиг, Дамдин нарыг хилсээр татаж шахалтад оруулаад ийнхүү үйлдэж өгснийх нь төлөө энэ удаа ял тулгалгүй мулталсан байхыг үгүйсгэхгүй. Учир нь, хожим 1937 онд ёнзин хамба Лувсанхаймчиг өөрийн байцаалтын мэдүүлэгтээ⁵ “удирдагч болох тайж Эрэгдэндагвын бие Хятад улсад очиж харилцаа хийхээр явж зам зуур баригдан... хууль ёсоор шийтгэгдсэн. Үүнд Ёнзон миний бие нэгэн адил баригдсан боловч хуулийн газар үл шилжсэн болой”(Төв, хууд. 156) гэсэн байдаг. Гэвч энэ тухай цаашид нягтлан тодруулах шаардлагатай юм.

Харин цаг хугацааны хувьд, Эрэгдэндагвын хэрэгт хүмүүсийг татаж эхлэхтэй зэрэгцэн энэхүү суртал ухуулгыг хүчтэй хийх болсон нь большевикууд энэ удаагийн Эрэгдэндагвад холбогдох хэргийг эсэргүү бүлгэмийн хэрэг болгон зохион өргөжүүлж, түүнийгээ хувьсгалт хууль ёсоор нэр халхлан зохиомол хэргээр хүмүүсийг цээрлүүлэх завхралаа зүй ёсны зүйл болгон харуулах, ерөөс урьд хожид үйлдсэн хэлмэгдүүлэлтээ нэг мөр зөвтгөж, ард олноос тал олох гэсэн нэлээд башир аргыг сэджээ гэж үзэж байна.

1930-аад оны эхэн үеэс БНМАУ-д соёлын салбарт үзэл суртлын хяналт орж, дээд, дунд ангийн лам нарын талаар зөвхөн сөрөг тайлбар өгөхийг нам, төрийн үзэл суртал албадах болсноор лам нарыг урвагч, Банчин богдыг дайсанд үзсэн суртал ухуулга утга зохиолд нэвтрэн орж иржээ. Нэгэн жишээ татахад, Монголын анхны ший жүжгийн бүлгэмийн уран сайханч, зохиолч Ш.Аюушийн 1935 онд хэвлүүлсэн “Өвгөн феодалын үг” хэмээх найраглалд,

5 1937 онд хувьсгалын эсэргүү лам нарын “төв” бүлгэм гэгч хэргээр Эрэгдэндагвын хэргийг дахин сөхөж ёнзин хамба Лувсанхаймчиг, дэд хамба Дамдин, Манзушир хутагт Цэрэнддорж, Чойнзин цорж нарыг Банчин богдын итгэмжлэгдсэн тагнуул, хувьсгалын эсэргүү “төв” бүлгэмийн гол толгойлогчид хэмээн гүтгэж тэдэнд ялын дээд хэмжээ оноосон билээ.

монголын хар, шар “феодалууд” Япон болон Банчин богдоос тусламж эрж төр, засгийг устгахаар үгсэн хуйвалдах авч тэр нь илчлэгдэн хуулиар шийтгэгдэж байгаа тухай өгүүлжээ. Энэ тухай дараах байдлаар бичсэн байна.

“Харгис дайсан феодал гэдэг нэртэй болж...
Урьдын байдлыг байгуулахын төлөөнөө урьдаар бид нар
Ухаан санаа сүвэгчилж улааны засгийг устгахыг бодож
Хамгийн түрүүнд хайртай хань нөхдөдөө хэлж
Халх монголын хилээс оргож яваад
Японд очиж хэлээд явдлаа бүтээхийн төлөөнөө
Банчинд бараалхаж байдал учраа тоочиж хэлээд
Эгж ирээд эзэн хааны засгийг байгуулж
Энэ муусайн ардуудыг эрхэндээ эгүүлэн авахаар...

Хэдэн нөхдийн дотроос дуртай нэгийгээ томилж
Хэзээ явуулахыг шийдэж хэлэлцээд тарав...
Ховдог шунахай бодлого минь илэрч
Хуулийн газар шилжээд
Японд ч очиж чадсангүй
Явдал хэргээ ч бүтээсэнгүй
Банчинд ч бараалхаж чадсангүй байгаад
Балагтай хэрэг болж баригдав...
Банчин богдыг сонсож
Бараалхах юм сан гэж бодно
Баригдах хоригдохоос айгаад
Бас чадахгүй юм даа”(Ши.Аюуш, 1935) гэх зэргээр бичжээ.

Ийнхүү ардын засгийн үед өсөж хүмүүжсэн шинэ сэхээтнүүд өөрсдийн уран бүтээлдээ шашны ов мэх, харгис мөн чанарыг илрүүлэх нэрээр Банчин богд ба шашин, лам нарыг муучлан байжээ.

Соёл, урлагаар дамжуулан явуулах суртал ухуулгын нэг гол салбар нь кино урлаг байв. Монголд хөгжиж эхэлсэн кино урлаг үүссэн цагаасаа ард олны дунд буддын

шашныг сөрөг утгаар сурталчлах нь МАХН-ын үзэл суртлын зэвсэг болж хувирсан билээ (Д.Ундраа, 2019, хууд. 248). Иймээс өмнөх нийгмийн үед уран сайхны кинонд ч Банчин богдын эсрэг үзэл суртлын агуулгыг тусгасан зүйл буй. Тухайлбал, хожим 1970-1973 онд бүтээгдсэн боловч өнөөдрийг хүртэл Монголчуудын үзэх дуртай киноны нэг болох “Тунгалаг тамир” хэмээх бүрэн хэмжээний 3 ангитай киноны 3-р ангид, Богд Жавзандамба хутагтыг таалал болсны дараа төр, засгийн эсрэг үгсэн бүлэглэсэн монголын лам нар есдүгээр дүрийн Банчин богдтой нууц холбоо тогтоох гэж оролдож байсан мэтээр тодорхой дүрслэн үзүүлсэн байдаг.

Энэ бүхэнтэй зэрэгцэн Банчин богдын Монгол дахь хувьсгалын эсэргүү ажлыг илчилж, түүнийг Монголын ард түмний дунд эгнэгт жигшүүлэх гэсэн суртал ухуулгын ажлыг хүчтэй явуулж байю. Энэ тухай суртал ухуулга тухайн үеийн сонин, сэтгүүлүүдэд нийтлэгдсэн байдлыг үзвэл, монгол (Лам нарын сэтгүүл, 1936, 1937), орос (Современная Монголия, 1937) хэлээр мөн монгол бичигт тайлагдаагүй лам нарт зориулж монгол хэлийг төвөд үсгээр (Лам нарын сэтгүүл, 1936, 1937) галиглан бичиж хэвлэж байжээ. Жишээ нь “Лам нарын сэтгүүл”-ийн 1937 оны эхний дугаарт буй “Эдүгээ цагийн хувилгаан хэмээгдэх Банчин нугуудын тухай” гэсэн том гарчигтай нийтлэлд бичсэнээр, Банчин богд бол илжиг лугаа адил эрдэм ном эс сурсан, гагцхүү амины ашиг олз, эрх жаргалант шунаж, Англи, Хятадтай сүлбээлж Төвөд орныг гадна, дотно болгон хувааж хар, шар олныг үймүүлэн хутгасан, гадаадын балмад дайсан Япон, Хятадын цэрэг лүгээ нийлэлдэн амьтныг алах талах бэлтгэл үйлдэж, эх орон, төр түмэн, өөрийн шүтэн барилдсан багш Далай ламын эсрэг урван тэрсэлсэн, эцэг юүгээн алуулахыг оролдсон, гэлэн хүний сахил санваар, ном бурхны ёсыг зөрчиж бурхны шашинд туйлын

их хор зэтгэр болсон үл бүтэх явдалтай жигшүүрт хүн мөн тул түүнийг бурхны хувилгаан хэмээх нь үнэхээр инээдтэй гэх зэргээр гутаан доромжилж бичжээ (Лам нарын сэтгүүл, 1937, хууд.26-30).

Дөрөв. Банчин богдын нэрээр тархаасан нэгэн ухуулах бичгийн агуулга

Коминтерн болон МАХН-аас хэрэгжүүлж байсан суртал ухуулгын ажлууд нь тухайн үед Монгол, Өвөр Монголын сүсэгтэн олны дунд оройн дээдлэн шүтэгдэж байсан Банчин богдын эсрэг үр дүнгээ хэр сайн өгч байсныг одоо хэлэхэд хэцүү юм. Харин лам нар, шашиндаа туйлын үнэнч сүсэгтнүүд эсвэл хэн нэгний зүгээс 1920-иод оны дунд үеэс эхлүүлэн 1930-аад оны турш Улаантнуудын эсрэг Банчин богдыг сөргүүлж тавьсан бичгээр болон амаар тархааж байсан идэвхтэй суртал ухуулгад л ард олон амархан итгэж байсныг тэмдэглэх хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, шашин, үндсээ авч үлдэх гэсэн сүсэгтэн монголчуудын санаа сэтгэл большевикуудыг хөөж, шашныг аврах Банчин богдын залралд зайлшгүй гэдэгт итгэхийг илүү их хүсэж байсан гэдэг нь үнэн юм.

МАХН-аас Банчин богдын “аюул”-ын тухай суртал нэвтрүүлгийг идэвхтэй хийж байх үед эсрэгээрээ Банчин богдын лүндэн, сургаал нэртэй ухуулгын материалууд 1920-иод дунд үеэс эхлэн ар, өвөр Монголд, бүр Буриадад (Төв, хууд. 161) тархаж байжээ. Гэвч эдүгээ хадгалагдаж ирсэн нь тун ховор бололтой. Энд жишээ болгож судлаач Б.Зинамидарын номдоо оруулсан “Богд Банчин Эрдэнийн зарлиг” хэмээх муутуу цаасан дээр хар бэхээр монгол бичгээр бичсэн, ямар нэгэн тамга тэмдэг байхгүй бичгийн (Б.Зинамидар, 2018, хууд. 53) агуулгыг авч үзье. Түүнд, “Богд Банчин Эрдэнийн зарлиг ану, олон төрөлхтөн хийгээд аливаа ном төгсгөсөн гуравдугаар Монголчуудын нүглийн зовлонг арилгахын тулд ухуулах бичгийг тараав... Ертөнцийн хүний нүглийн сав дүүрчээ. Нэгдүгээрт,

эцэг эхээ хайрлахгүй, хоёрдугаарт эцэг эхээ элдэвлэн зовоох, гуравдугаарт тэнгэр газрыг хараах, дөрөвдүгээрт, амьтныг алахыг цээрлэхгүй, тавдугаарт, хүнийг муучлах, зургаадугаарт, их багатай тэмцэх сэтгэл үүсгэх, нууцаар дарлах, долоодугаарт, шударга хүнийг дарлах, наймдугаарт, амийг бодон хайрлахгүй, есдүгээрт, муу үйл үйлдэх, сайнаар явахгүй нэг мөсөн нүглийн савыг дүүрчүхүй. Тэнгэр уур хүрч хорин найман одыг ертөнцөд буулгаж дэлхий дахинд самуун үүсэж, жигшүүрт заль, мууг хорих цаг болов. Монголчууд сүсэг бишрэлээ сайн хичээ. Муугаар бүү явсугай. Зовлонгоос гэтэлж чадмуй. Таван цөвүүн болсон тул арван хувиас есөн хувь нь үхмүй. Есөн эхнэр нэг эрийг дагана. Хөх хулгана жилээс эхлэн зовлон хүнд болно. Цагаан морин жил цаг тэгширмүй. Ертөнцийн хүний их аюул буй” гээд үүнд гал, ус, зэвсэг, цэрэг дайны, хулгайн, хорт могойн, чоно, барсын, догшин бурхны, өлсөхийн, эцэг эх, эр, эм, ах дүү нар салж, үл учрахын зэрэг нийт арван аюул тохиолдох тул энэхүү “аюулаас гэтлэх бэрхийн цаг болов. Аливаа хүн сэтгэлээ хичээ. Хүмүүний үхдэлээр гуу суваг дүүрнэ. Цус нь гол болж урсана. Зам байвч явах хүн үгүй, гэр байвч суух хүн үгүй, дээл байвч өмсөх хүн үгүй ийм цаг болов... Баян гэж битгий сана, хоосон гэж битгий гомд, Баян ядуу амармуй. Сүсэг бишрэлээ хичээ. Хэн хүн энэ зарлигийн номыг буруу санавал хамар амнаас цус гарч үхмүй. Муугаа халж сайнаар явбаас цөвүүн цагаас гэтэлж болно... Олон Монголчууд сүсэг бишрэлээ хичээ. Монгол эр нар гол гатлан гарч бичгийн нэгэн хуудас тарааваас нэгэн биеийн зовлон арилна. Цаашид хүн хэвлээд хот бүхэнд тарааваас нас үлэмж үүл мэт цоглуун, хэргэм, мэдэл, санасан хэрэг сэтгэлчлэн бүтэх болтугай. Энэ зарлигийг хүн гэртээ дарагдуулбаас муу болно. Маань мэгзэм сайн уншиж эрхэмлэн хичээ. Өлзий хутаг орших болтугай. Ум Мани Бад Мэ Хум” (Б.Зинамидар, 2018, хууд. 53) гэжээ.

Ухуулах бичгийн гол агуулгыг задлан үзвэл, аль нэг газар орны бус ерөөс “ертөнцийн хүмүүсийн нүглийн сав дүүрсэн” бөгөөд шалтгаан нь хүмүүс амьтны амь таслах тэргүүтэй есөн төрлийн муу үйлийг үйлдсэнээс болсон ажээ. Иймээс хүн төрөлхтөнд таван цөвүүн цаг тохиож буй учир дээд тэнгэр хилэгнэн тэрхүү жигшүүрт мууг хорьж таслах арга хэмжээ авахаар бууж ирэх бөгөөд тэр гэсгээлийн үед ертөнцийн хүнд арван их аюулаас гэтлэх бэрх, хэцүү цаг учрах гэнэ. Иймд тэдгээр аюулаас гэтэлгэж, “Монголчуудын нүглийн зовлонг арилгахын тулд” энэ нэгэн ухуулах бичгийг Банчин богд бээр үйлдэн тархааж урьдчилан анхааруулж буй учир “олон төрөлхтөн хийгээд аливаа ном төгсгөсөн... Монголчуудаас” маань, мэгзмээ сайн уншиж, сүсэг бишрэлээ хичээж, “муугаа халж сайнаар явбаас цөвүүн цагаас гэтэлж болно” гэж бичжээ.

Гэвч энэхүү ухуулга бичгийг гагцхүү есдүгээр дүрийн Банчин богд зохиосон эсвэл хэн нэгэн үл таних хүн шинээр бичиж гаргасан зүйл ч биш бололтой. Учир нь эдүгээ Монгол улсын Үндэсний нийтийн номын санд хадгалагдаж байгаа наймдугаар Богд Живзүндамба хутагтын 1902 онд зохиосон⁶ “Живзүндамба гэгээнтний лүндэн” хэмээх модон барын төвөд нэг хуудас судар болон түүний монгол бичгээр бичсэн гар бичмэл судрын гурван хувилбар (Богдын лүндэнгийн бичиг болой, 1902, 4686/96), мөн арай хожуу автономитын үед буюу “1917 оны төмөр туулай жилийн өвлийн сүүл сарын 27-нд Богд Живзүндамба хааны айлдсан нэгэн лүндэнд” (Г.Пүрэвбат, 2010) өгүүлсэн зүйлс энэхүү “Богд Банчин Эрдэнийн зарлиг”-тай утга санаа ижил төстэй, зарим хэсэг нь үг үсэггүй адил байгаа юм. Иймээс 1920-иод оны сүүл, 30-аад онд Банчин богдын нэрээр гарч

улаантны эсрэг шашны суртал нэвтрүүлэг мэтээр тархаагдаж байсан тэдгээр ухуулгын зарим нь олон жилийн өмнө наймдугаар Богд Живзүндамбын зохиосон лүндэн сургаал, ерөөлүүдийн (Монгол улсын хаан, VIII Богд Жавзандамба хутагтын буман зарлиг, 2019) зарим нэг нэмж хассан болон засамжилж найруулсан хувилбарууд байжээ. Наймдугаар Богдын зохиосон лүндэн сургаалууд нь ирээдүйд тохиож болзошгүй сайн, мууг айлдаж, тэрхүү цагийн хэцүүд сэрэмжтэй байж, явдал мөрөө хичээж явахыг сануулсан байдаг нь өнөөдөр ч ач холбогдлоо алдаагүй байдаг.

Үүнтэй нэгэн адил Банчин богдын нэрээр гаргасан энэхүү ухуулгад Улаантнуудын эсрэг эсвэл Монголын засгийн газрын эсрэг ард олныг турхирсан гэх ямар нэгэн илэрхий утга огт байхгүй байна. Гэвч магадгүй цөвүүн цаг тохиож их аюул нүүрлэх тухай бичиж, энэ нь биелэх цаг болсон мэтээр олон жилийн турш аман яриагаар болон бичгээр тархаагдаж байсан тул энэ нь олон нийтийг айдаст автуулж, нийгмийн сэтгэлзүйг тогтворгүй болгох, улмаар Улаантнууд төр барьж шашны эсрэг бодлого хэрэгжүүлж байгаагаас үүдэн шашин доройтсон цөвүүн цагийн тэрхүү аюул нүүрлэх гэж байгаа мэт ойлголтыг ард олонд өгч, Улаантныг үзэн ядах сэтгэлийг өсгөсөн байж болох юм. Иймээс Большевикууд түүнийг өөрсдийнх нь эсрэг суртал ухуулга хэмээн харж байсан бололтой.

Ийнхүү Монгол Ардын Хувьсгалт Намаас хувьсгалын эсрэг ухуулга, лүндэнг Банчин богдын нэрээр хэн нэгэн гаргаж эсвэл Банчин богд өөрөө ч энэ бүхнийг үйлдэж ард олныг өдөөн турхирч байна гэж үзсэний дүнд 1929 оны 6 дугаар сарын 3-нд Намын Төв Хорооны дэргэдэх Шашны Хэргийн комиссын ээлжит хурлаас “... хутагт хувилгаадын лүндэн зарлиг хэмээх

6 “Живзүндамба гэгээнтэний лүндэн”-гийн төгсгөлийн үгэнд “Арван тавдугаар жарны усан бар жил монгол хэлнээс төвөд хэлэнд орчуулсны сайн буян дэлгэртүгэй” (Ч.Гансүхын орчуулга) гэжээ. Тус усан бар жил нь аргын тооллоор 1902 он болно.

нэрийдлээр улс төрд хортой зүйл хэвлэн тарааж олныг мунхруулах зэргийн явдлууд зүйл зүйлээр илэрч буй” (Төв, хууд. 34) энэ явдлыг бүр мөсөн цаазлан зогсоож нийтэд зарлан дагаж шийтгүүлэхээр тогтжээ.

1929 оны 10-р сарын 4-нд Засгийн газрын Эрхлэх товчооны 95 дугаар хурлаар “... зах дэлгүүрийн хятадууд, нам, засгийн тэрслүү шар харгис Банчин богд зэргийн хутагт хувилгаадын зургийг үлэмжхэнээр гоёмсоглон худалдаж ашгийг олж, ард түмэнд сэтгэл бишрэл төрүүлэн тэдний зүг хандуулах явдал буй” (Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхтгэл, 2010, хууд. 197) хэмээн үзээд “хутагт хувилгаадын зургийг худалдаалахыг бүр мөсөн зогсоох тухай” тогтоол гаргаж, улмаар “Хятад худалдаачдаас Банчин богдын зургийг худалдаалахыг зогсоосон тухай Намын Төв Хорооны бичиг” (Төв, хууд.183-184)-ийг хот, аймаг сум, хязгаарын зохих газруудад бүгдэд зарлан илгээж байжээ.



Зураг 4. 1920, 30-аад оны үед тархаагдаж байсан есдүгээр Банчин богдын нэгэн фото зураг.

Шашны үүднээс суртал ухуулга хийх, цуу үг тараахыг хориглосон заалтыг хожим 1934 оны “Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Шүүх цаазын бичиг” (Шүүх явдлын яам, 1934, хууд.198) болон “Төр, шашныг тусгаарлан явуулах тухай хууль”-д оруулан тогтоож өгсөн юм. Тухайлбал, тус хуулийн 3 дугаар зүйлд: “Шашин шүтлэгийн явдлыг улс төр ба ардын засаг хийгээд ард түмэнд хорлолтойгоор тайлбарлан ухуулах ба ашиглах, хэрэглэх буюу... шашны үйл хэргийг бүтээх нэрийдлээр буюу ард түмний сүсэг бишрэлийг санаатайгаар ашиглах зэргээр улсын дотроо тогтоосон журам байдлыг зөрчих, ард түмнийг хутган үймүүлэх зорилгоор хууран мэхлэх, цуу үг тараах буюу шашны сургаалаар далайлган бусад зүй бус аргаар ард түмнийг хутган үймүүлж самууруулах зэрэг хэрэг үйлдэх явдлыг хуулиар цээрлэх тул гэмт этгээдийг эрүүгийн хатуу хариуцлагад татаж хүндэд цээрлүүлэн шийтгэмүй” (Төв, хууд.70) гэж заасан байдаг.

Мөн үед Банчин богд орж ирвэл үзэгдсэн газарт нь баривчил хэмээн түүний фото зургийг хилийн харуулуудад ирүүлж, мөн хязгаарын сайд Бумцэндээс бид Банчин тангадаас айхгүй хэмээн өгүүлж байсан гэж төр, цэргийн ахмад зүтгэлтэн Б.Цэдэн-Иш тухайн үед хилийн цэрэгт алба хашиж байхдаа өөрийн нүдээр үзсэнээ дуртгалдаа бичсэн байна (Б.Цэдэн-Иш, 2005, хууд. 295). Энэ мэтээр сүржигнэж, Банчин богдын “аюул” Монголд бодитой нүүрлээд байна гэсэн суртал ухуулгад хүмүүсийг итгүүлж чадаж байжээ. Дашрамд дурдахад, есдүгээр Банчин богдын хөрөг зураг өнөөдөр ч Өвөр Монголын зарим айлын хойморт залагдан шүтэгдэж байдгийг түүхч боржигин Бүрэнсайн зургийг нь авч, энэ тухай илтгэлдээ тэмдэглэсэн байдаг (布仁赛音, 2019年).

Дүгнэлт

XX зууны 20, 30-аад оны Монголын түүхэнд холбогдох олон асуудлуудыг Зөвлөлт, Коминтерний Монголын талаар хэрэгжүүлсэн бодлогоос ангид авч үзэх боломжгүй юм. Үүнд Төвөдөөс оргож Хятад, Өвөр Монголд ирж амьдрах болсон есдүгээр Банчин богдыг 1920-иод оны сүүлч үеэс эхлэн Коминтерн болон МАХН-аас дайсанд үзэж, улмаар түүний эсрэг суртал нэвтрүүлгийг 1930-аад оны туршид хэрэгжүүлсэн асуудал багтана. Коминтерн болон МАХН-аас Банчин богдыг дайсанд үзэхэд дотоод, гадаад олон хүчин зүйл нөлөөлсний нэг нь, Банчин богд Хятадад ирснийхээ дараа Монголын дайсан Японтой холбоотой Хятадын Мүгдэний цэргийн эрхтэн Жан Зуолинтой харилцаа тогтоож, улмаар Өвөр Монголоор аялан ном айлдах болсон тул Коминтерноос Банчин богдыг Японы бодлоготой холбон үзэж, Япон нь БНМАУ-ын эсрэг бодлогодоо Банчин богдыг ашиглаж байна гэж дүгнэжээ. Улмаар VIII Богд Жавзандамба хутагтыг таалал болж шашны удирдагчгүй болсон лам нар Зөвлөлтийн бодлогыг сөрж Монголд хуучны ёсыг тогтоохоор Банчин богдоос тусламж хүснэ гэж Зөвлөлт, Коминтерний удирдагчид хардаж, нэн даруй Банчин богд болон Монголын лам нар, сүсэгтэн олныг холбоог таслах зорилго тавьжээ,

Коминтерн болон МАХН-аас Японы БНМАУ-ын талаарх бодлогыг хэлэлцэн, Япон улсаас Монголыг дотроос нь буюу хар, шар феодалуудыг турхиран бослого гаргах, эсвэл гаднаас хувьсгалын эсэргүү нарыг ашиглан өөрийнхөө эсрэг өдөөн хатгаж дайн үүсгэх замаар Монголыг эзлэх бодлого тавьж, түүндээ Банчин богдыг гол болгон ашиглаж байна гэж үзжээ. Цаашилбал Япон нь Зөвлөлтийн бодлогыг эсэргүүцсэн гадаад, дотоодын хүчнүүдийг пан-монголын лоозон дор Банчин богдоор дамжуулан нэгтгэж болзошгүй гэдгээс Зөвлөлт, Коминтерний удирдагчид ихэд болгоомжилж байв.

Гэвч тухайн үед Зөвлөлтөөс Японыг шууд сөрөх хүчин мөхөс байсан тул эхлээд Япон ба Банчин богдыг харлуулах суртал нэвтрүүлгийг хүчтэй хийж Монгол дахь аюулгүй байдлаа хангах, улмаар Монголд Япон, Банчин богдын “аюул занал” бодитой нүүрлээ гэсэн айдсын сэтгэлзүйг Монголчуудад төрүүлж, эцэст нь Монгол дахь өөрсдийн гол дайснаа гэж үзсэн Монголын лам нарыг Банчин богдын хань хамсаатан, тагнуул нэрээр залхаан цээрлүүлэх их хэлмэгдүүлэлтээ хийжээ.

Ном зүй

1. МУУТА, МАН-ын Баримтын төв. Ф-7, Д-4, ХН-35.
2. МУУТА, МАН-ын Баримтын төв. Х-4, Д-7, ХН-55.
3. МУУТА, МАН-ын Баримтын төв. Х-4, Д-6, ХН-80.
4. МУУТА, МАН-ын Баримтын төв. Х-4, Д-3, ХН-92.
5. МУУТА, МАН-ын Баримтын төв. Х-4, Д-3, ХН-133.
6. МУУТА, МАН-ын Баримтын төв. Х-4, Д-4, ХН-185.
7. МУУТА, МАН-ын Баримтын төв. Х-4, Д-3, ХН-279.
8. МУУТА, МАН-ын Баримтын төв. Цуглуулга Хөмрөг-7, Д-1, ХН-22.
9. МУУТА, МАН-ын Баримтын төв. Цуглуулга Хөмрөг-7, Д-1, ХН-24.
10. МУУТА, МАН-ын Баримтын төв. Цуглуулга Хөмрөг-7, Д-1, ХН-27.
11. 中国第二历史档案馆, 中国藏学研究中心合编:《九世班禅内地活动及返藏受阻档案选编》, 中国藏学出版社, 1992年
12. Банчин богдын тухай ухуулах бичиг. Долоннуур., 1929.
13. “Богдын лүндэнгийн бичиг болой”, дугаар 4686/96.
14. “Богд гэгээнтний зарлиг сургаалыг оршуулбай”, дугаар 4692/96.
15. “Богд гэгээнтний зарлиг сургаалыг оршуулбай” 1902 он. дугаар 3527/96.
16. Гандан Хүрээний Шашны Захиргааны газраас тус шашны ядуу, дунд ангийн лам нарт ухуулан зарлах бичиг. УБ., 1930.
17. Лам нарын сэтгүүл. 1936 он. №2.
18. Лам нарын сэтгүүл. 1937 он. № 1-2 (5-6).
19. Монгол Ард Улсын Бага Хурлын Тэргүүлэгчид ба Засгийн газрын хуулиуд хийгээд тушаалуудыг эмхэтгэн хавсруулсан сэтгүүл. Шүүх явдлын яам. №75 (2), УБ., 1934.
20. Современная Монголия. №2 (2). 1937 г.
21. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Их Бага Хурлын тогтоол, Үндсэн хууль, Тунхгууд. Эмхтгэсэн Ц.Насанбалжир. Улсын хэвлэлийн газар. УБ., 1956.
22. БНМАУ-лс хөрөнгөтний биш хөгжлийн төлөө тэмцэлд. Баримт бичгүүд (1925-1940). Эмхтгэсэн Ц.Насанбалжир. Улсын хэвлэл. УБ., 1956.
23. МАХН-ын түүхэнд холбогдох баримт бичгүүд. 1920-1940. УБ., 1966.
24. Монгол улсын хаан, VIII Богд Жавзандамба хутагтын буман зарлиг. УБ., 2019.
25. Улсын 6 дугаар Их хурлын илтгэл. тэргүүн дэвтэр. УБ., 1930.
26. Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхтгэл. Гуравдугаар боть. 1926 VI сар – 1936 он. УБ., 2010.
27. Коминтерн ба Монгол. (баримтын эмхтгэл). ЭШ-ний удирдагч Ч.Дашдаваа, В.П.Козлов. УБ., 1996.
28. Ван Мин. О Положении В Манчжурии И Новом Наступлении японии на китаи и монголию. Перевод Дамба-Доржи. Техник редактор Хен-Иргу.
29. Ван Мин. Манжуур дахь байдал хийгээд Японы Хятад ба Монголыг шинэ довтлон халдах тухай. Ленинград., 1933 г.
30. Ши.Аюуш. Өвгөн феодалын үг. “Монгол ардын үндэсний соёлын зам” сэтгүүл, 1935 оны дугаар №7, Улаанбаатар., 1935.
31. Базарын Цэдэн-Иш. УБ., 2005.
32. Ж.Болдбаатар. XX зууны Монгол Улс. Шилдэг үзмэрийн дээжис. 1921-1952. УБ., 2017.
33. Богдын лүндэн. Эрхэлсэн Г.Пүрэвбат. УБ., 2010.
34. Б.Дашцэвэг. МАХН-аас Шарын шашин, түүний үлдэгдлийн эсрэг явуулсан тэмцлийн зарим асуудал. Улсын хэвлэлийн газар. УБ., 1976.
35. Дилов хутагт Жамсранжав. Ариун сэтгэл, авралын үндэс.(дуртгал,

- намтар, өгүүлэл). Хэвлэлд бэлтгэсэн Л.Чойжилсүрэн. УБ., 2000.
36. Г.Мягмарсамбуу. Монголын шашин, төрийн нэрт зүтгэлтэн Егүзэр хутагт Жамсранжавын Галсандаш (1870-1930). УБ., 2014.
37. Б.Зинамидар. Шамбалын дайн ба халх голын дайн. УБ., 2018.
38. С.Л.Кузьмин. Ж.Оюунчимэг. Социализмын эсрэг 1932 оны Монгол дахь бослого. УБ., 2014.
39. О.Одбаяр. Зүүн хязгаарын Монголчуудын оюун санааны их удирдагч Егүзэр хутагт Галсандаш. УБ., 2012.
40. С.Пүрэвжав, Д.Дашжамц. БНМАУ-д сүм хийд, лам нарын асуудлыг шийдвэрлэсэн нь. 1921-1940. Улсын хэвлэлийн хэрэг эрхлэх хороо. УБ., 1965.
41. О.Бумдарь. Төвөдөөс дүрвэсэн есдүгээр Банчин богдын талаарх олон улсын ашиг сонирхол ба зөрчил (1923-1928). *Historia Mongolarum*, Tom. XX, № 20 (576), National University of Mongolia, УБ., 2021.
42. Д.Дашдулам. Монголд 1930-аад оны улс төрийн хэлмэгдүүлэлтийг хийх нийгмийн сэтгэл зүйг бэлдсэн нь. Улс төрийн хэлмэгдүүлэлт: шалтгаан, үр дагавар, сургамж. ОУЭШ-ний бага хурлын эмхэтгэл. Эмхэтгэсэн П.Нарандалай, П.Оюун. УБ., 2017.
43. Д.Наранжаргал, Ч.Дашдаваа. Мэрсээгийн амьдралын сүүлийн жилүүд. Өвөр Монголын Их сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүл. 2014 оны дугаар 6. Тусгай дугаар. Хөх Хот 2014.
44. Д.Ундраа. Социализмын үеийн монгол кинонд буддын шашныг гуйвуулан дүрсэлсэн үү?. Философи, эрхийн судлал. 24 дүгээр боть. УБ., 2019.
45. Цолмон. Дотоод Монголын Ардын Хувьсгалт нам болон Цахар хошуудын хоорондох харилцааны тухай (1925-1931). Өвөр Монголын Их сургуулийн эрдэм шинжилгээний бичиг. 2019 оны 1 дүгээр хугацаа. Хөх хот., 2019.
46. 阿.恩克巴图, 额尔根巴亚尔, 《我们所知道的郭道甫》, 《呼伦贝尔史志资料》第1辑, 1985年, 第126页。
47. 那木海扎布, 《东蒙要事杂忆》, 《内蒙古文史资料》, 第三十一辑, 1988年, 第196页。
48. 陈柏薄: 《九世班禅在内地的政教活动述略》, 青海: 青海民族大学学报(社会科学版), 第2期, 2012年4月, 页-37。
49. 布仁赛音: 《九世班禅与1920年代的内蒙古社会》, 《内蒙古大学民族学与社会学学院系列讲座》(二), 2019年11月3日。

Abstract:

Since the end of the 1920s, the Communist International and the Mongolian People's Revolutionary Party have concluded that the 9th Panchen Bogd, who fled Tibet to China and Inner Mongolia in 1923, was used for Japan's policy against the Mongolian People's Republic. Therefore, Communist International and the Mongolian People's Revolutionary Party began to actively carry out propaganda work in Mongolian People's Republic and Inner Mongolia to slander the 9th Panchen Bogd. The article discusses how this propaganda work was carried out based on relevant facts.